

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/93/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМАГ СЭРГЭЛЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ж.Бямбацогт

Утас: 70273204 Цахим хаяг: byambatsogtj@audit.gov.mn



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

Товчилсон үгийн жагсаалт	3
1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	14
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	19
4.1 Ерөнхий зүйл.....	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	20
4.5.1 Завсрын аудитын талаар.....	20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	21
5.1 Төлбөрийн акт	22
5.2 Албан шаардлага	22
5.3 Зөвлөмж.....	23
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ	24
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл	24
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	25
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХК	Хувьцаат компани
ТӨХК	Төрийн өмчит Хувьцаат компани
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/01
танай _____ -ны № _____ -т

Г **Хязгаарлалттай дүгнэлт** Г

ГТӨВ АЙМГИЙН СЭРГЭЛЭН СУМЫН Г
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Э.ЛХАГВАДУЛАМ ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 63,704.1 мянган төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Тус байгууллага тайлант онд морины шүтээн тохижилтын ажилд 185,464.5 мянган төгрөг, сумын өндөрлөг барихад 94,447.4 мянган төгрөг, Сэргэлэн сум байгуулагдсаны 100 жилийн ойтой холбоотой тэмдэг хийлгэхэд 11,919.6 мянган төгрөг, дууны клип хийлгэхэд 10,000.0 мянган төгрөг, баримтат кино хийлгэхэд 9,700.0 мянган төгрөг, номын эх бэлтгэхэд 19,400.0 мянган төгрөг зарцуулсан байна.

G/Архив/Албан бичиг 2024/ А4

01000490

Аудитын гол асуудал

ТӨАСЭСЗДТГ/202309107 дугаартай гэрээгээр Гадаадын иргэн, харьяатын газар-агаарын замын боомт хариуцсан газрын ажилчдын автобусыг төсвийн хөрөнгө 99,800.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	720,135,749.0	689,218,211.2
33	АВЛАГА	12,532,069.0	616,432,158.0
3351	Байгууллагаас авах авлага	12,532,069.0	616,432,158.0
35	БАРАА МАТЕРИАЛ	707,603,680.0	72,786,053.2
35110	Тусгай зориулалттай материал	31,059,500.0	24,707,000.0
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	615,907,589.0	0.0
354	Хангамжийн материал	60,636,591.0	48,079,053.2
35410	Бичиг хэргийн материал	1,819,580.0	760,500.0
35420	Аж ахуйн материал	52,555,966.1	39,534,753.2
35450	Барилгын засварын материал	1,082,100.0	2,218,000.0
35470	Бусад хангамжийн материал	5,178,944.9	5,565,800.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,535,534,634.0	3,186,222,039.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,535,534,634.0	3,186,222,039.3
392	Биет хөрөнгө	1,524,134,634.0	3,161,632,039.3
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,024,981,169.8	2,618,502,464.6
39202	Хуримтлагдсан элэгдэл	-461,037,388.3	-516,064,220.8
39203	Авто-тээврийн хэрэгсэл	446,511,106.0	585,979,440.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-145,764,956.0	-205,435,068.8
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	234,761,686.0	249,694,596.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-65,668,613.7	-74,902,913.5
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,187,000.0	62,853,700.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,175,510.8	-26,599,233.7
39214	Бусад үндсэн хөрөнгө	735,584,589.2	762,768,311.6
39215	Хуримтлагдсан элэгдэл	-284,244,448.3	-295,165,036.1
393	Биет бус хөрөнгө	11,400,000.0	24,590,000.0
39301	Програм хангамж	2,345,000.0	4,205,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,345,000.0	-2,015,000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	11,400,000.0	22,400,000.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,255,670,382.9	3,875,440,250.6
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	4,433,190.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	4,433,190.3
413	Өглөг	0.0	4,433,190.3
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	4,433,190.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,255,670,382.9	3,871,007,060.3
51	Засгийн газрын хувь оролцоо	2,255,670,382.9	3,871,007,060.3
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	892,403,903.0	892,403,903.0
51101	Өмч: - төрийн	892,403,903.0	892,403,903.0
512	Хуримтлагдсан үр дүн	1,329,555,770.7	2,944,892,448.0
51210	Өмнөх үеийн үр дүн	1,329,555,770.7	1,329,555,770.7
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	1,615,336,677.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	33,710,709.3	33,710,709.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,255,670,382.9	3,875,440,250.6

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,501,943,420.0	7,801,076,130.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	844,445,309.0	252,478,778.0
120	Нийтлэг татварын бус орлого	494,445,309.0	252,478,778.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	481,486,998.0	252,478,778.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,840,000.0	79,233,000.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	479,646,998.0	173,245,778.0
120009	Бусад орлого	12,958,311.0	0.0
122	Тусламжийн орлого	350,000,000.0	0.0
122001	Хандив тусламж /дотоод/	350,000,000.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,657,498,111.0	7,548,597,352.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	392,791,511.0	203,851,752.5
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	383,638,612.0	40,078,225.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,152,899.0	16,712,849.5
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,264,706,600.0	7,344,745,600.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,264,706,600.0	7,344,745,600.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,281,395,000.5	6,185,739,453.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	922,998,809.5	4,496,479,449.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	708,492,156.2	1,255,236,415.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,275,161.2	521,899,857.9
210101	Үндсэн цалин	178,934,258.6	368,242,556.3
210102	Нэмэгдэл	34,826,193.2	97,790,858.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,275,000.0	32,908,338.4
210104	Урамшуулал	4,109,173.4	19,815,298.4
210105	Гэрээт ажлын хөлс	1,130,536.0	3,142,806.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,175,116.5	64,980,501.5
210201	Тэтгэврийн даатгал	18,506,263.6	42,889,732.7
210202	Тэтгэмжийн даатгал	2,177,206.5	5,231,146.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,742,992.6	4,544,669.0
210204	Ажилгүйдлийн даатгал	427,476.7	2,034,888.8
210205	Эрүүл мэндийн даатгал	4,321,177.2	10,280,065.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,851,470.0	49,923,860.4
210301	Гэрэл, цахилгаан	27,257,470.0	36,927,286.0
210302	Түлш, халаалт	2,594,000.0	12,996,574.4
2104	Хангамж, бараа материалын зардал	28,482,103.2	56,006,124.7
210401	Бичиг хэрэг	2,758,520.0	5,094,400.0
210402	Тээвэр, шатахуун	21,790,383.2	34,760,014.3
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,913,200.0	3,062,500.0

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,020,000.0	520,000.0
210408	Бараа материал акталсны зардал	0.0	12,569,210.4
2105	Нормативт зардал	766,500.0	4,926,540.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	766,500.0	4,926,540.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,916,800.0	22,392,727.4
210604	Урсгал засвар	7,916,800.0	22,392,727.4
2107	Томилолт, зочны зардал	5,403,000.0	1,821,575.0
210702	Дотоод албан томилолт	5,403,000.0	1,821,575.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,391,774.0	14,369,906.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,020,214.0	14,108,906.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.0	0.0
210803	Даатгалын үйлчилгээ	798,128.0	0.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,168,432.0	0.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.0	261,000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	337,230,231.3	518,915,322.4
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	159,253,168.0	267,364,273.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	177,977,063.3	251,551,049.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	214,506,653.3	3,241,243,033.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,950,000.0	25,088,160.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	20,919,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,950,000.0	4,168,960.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	211,556,653.3	0.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	211,556,653.3	0.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.0	3,216,154,873.8
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	3,216,154,873.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	358,396,191.0	1,689,260,004.0
2200	Дотоод эх үүсвэрээр	358,396,191.0	1,689,260,004.0
220001	Барилга байгууламж	0.0	677,241,691.0
221001	Их засвар	243,460,047.0	701,927,388.0
222001	Тоног төхөөрөмж	180,000.0	97,065,853.0
223001	Бусад хөрөнгө	114,756,144.0	213,025,072.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,220,548,419.5	1,615,336,677.4
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,220,548,419.5	1,615,336,677.4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,022,296,422.0	7,627,830,352.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	364,798,311.0	79,233,000.0
120	Нийтлэг татварын бус орлого	14,798,311.0	79,233,000.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,840,000.0	79,233,000.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,840,000.0	79,233,000.0
122	Тусламжийн орлого	350,000,000.0	0.0
122001	Хандив тусламж /дотоод/	350,000,000.0	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,657,498,111.0	7,548,597,352.5
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	392,791,511.0	203,851,752.5
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	383,638,612.0	40,078,225.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,152,899.0	16,712,849.5
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,264,706,600.0	7,344,745,600.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,264,706,600.0	7,344,745,600.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	892,204,826.0	4,313,943,833.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	892,204,826.0	4,313,943,833.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	677,698,172.7	1,073,146,049.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	223,275,161.2	497,107,671.6
210101	Үндсэн цалин	178,934,258.6	329,694,044.1
210102	Нэмэгдэл	34,826,193.2	91,008,821.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,275,000.0	31,939,970.6
210104	Урамшуулал	4,109,173.4	26,581,494.5
210105	Гэрээт ажлын хөлс	1,130,536.0	17,883,341.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,175,116.5	62,726,874.0
210201	Тэтгэврийн даатгал	18,506,263.6	42,649,945.9
210202	Тэтгэмжийн даатгал	2,177,206.5	5,019,475.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,742,992.6	4,014,500.0
210204	Ажилгүйдлийн даатгал	427,476.7	1,003,516.8
210205	Эрүүл мэндийн даатгал	4,321,177.2	10,039,435.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,851,470.0	47,310,599.1
210301	Гэрэл, цахилгаан	27,257,470.0	35,385,000.0
210302	Түлш, халаалт	2,594,000.0	10,725,599.1
210303	Цэвэр, бохир ус	0.0	1,200,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	25,732,500.0	30,913,589.0
210401	Бичиг хэрэг	2,532,500.0	3,524,920.0
210402	Тээвэр, шатахуун	16,615,000.0	19,498,869.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,910,000.0	2,906,100.0
210404	Ном, хэвлэл	205,000.0	0.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,470,000.0	4,983,700.0

2105	Нормативт зардал	4,000,000.0	1,700,000.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,000,000.0	1,700,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,600,800.0	13,998,970.0
210604	Урсгал засвар	8,600,800.0	13,998,970.0
2107	Томилолт, зочны зардал	5,403,000.0	1,788,000.0
210702	Дотоод албан томилолт	5,403,000.0	1,788,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,391,774.0	18,841,433.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	46,020,214.0	17,538,602.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	350,000.0	432,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	798,128.0	24,000.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,168,432.0	846,831.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.0	0.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	305,268,351.0	398,758,913.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	305,268,351.0	398,758,913.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	214,506,653.3	3,240,797,783.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,950,000.0	24,642,910.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	20,919,200.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,950,000.0	3,723,710.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	211,556,653.3	0.0
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	211,556,653.3	0.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.0	3,216,154,873.8
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	3,216,154,873.8
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	1,130,091,596.0	3,313,886,518.8
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,130,091,596.0	3,313,886,518.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,130,091,596.0	3,313,886,518.8
2200	Дотоод эх үүсвэрээр	1,130,091,596.0	3,313,886,518.8
220001	Барилга байгууламж	615,907,589.0	1,621,688,814.0
221001	Их засвар	265,649,323.0	714,700,000.0
222001	Тоног төхөөрөмж	69,278,540.0	455,528,351.8
223001	Бусад хөрөнгө	139,756,144.0	521,969,353.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	39,500,000.0	0.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,130,091,596.0	-3,313,886,518.8
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	881,003,903.0	34,149,535.7	641,438,535.9	1,556,591,974.6
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	881,003,903.0	34,149,535.7	641,438,535.9	1,556,591,974.6
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(17,904,669.3)	(17,904,669.3)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,403,903.0	33,710,709.3	1,329,555,770.7	2,255,670,382.9
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	892,403,903.0	33,710,709.3	1,329,555,770.7	2,255,670,382.9
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	892,403,903.0	33,710,709.3	1,329,555,770.7	2,255,670,382.9
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,615,336,677.4	1,615,336,677.4
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	892,403,903.0	33,710,709.3	2,944,892,448.0	3,871,007,060.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,524,292,100.00	4,192,012,221.18
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,141,351,100.00	878,125,702.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,116,431,900.00	853,482,792.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	501,805,900.00	497,101,047.28
210101	Үндсэн цалин	363,599,500.00	329,694,044.07
210102	Нэмэгдэл	92,342,400.00	91,002,197.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,864,000.00	31,939,970.62
210104	Урамшуулал	0.00	26,581,494.45
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	17,883,341.06
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,725,700.00	62,725,700.00
210201	Тэтгэврийн даатгал	42,653,500.00	42,653,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,018,000.00	5,018,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,014,500.00	4,014,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,003,600.00	1,003,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,036,100.00	10,036,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	47,326,000.00	47,310,599.12
210301	Гэрэл, цахилгаан	35,385,000.00	35,385,000.00
210302	Түлш, халаалт	10,741,000.00	10,725,599.12
210303	Цэвэр, бохир ус	1,200,000.00	1,200,000.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,933,900.00	30,913,589.00
210401	Бичиг хэрэг	3,525,000.00	3,524,920.00
210402	Тээвэр, шатахуун	19,498,900.00	19,498,869.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,910,000.00	2,906,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,000,000.00	4,983,700.00
2105	Нормативт зардал	1,700,000.00	1,700,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,700,000.00	1,700,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,000,000.00	13,999,970.00
210604	Урсгал засвар	14,000,000.00	13,999,970.00
2107	Томилолт, зочны зардал	2,006,400.00	1,788,000.00
210702	Дотоод албан томилолт	2,006,400.00	1,788,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,342,000.00	18,841,433.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,900,000.00	17,538,602.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,610,000.00	24,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,200,000.00	846,831.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	433,592,000.00	179,102,454.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	433,592,000.00	179,102,454.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,919,200.00	24,642,910.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,919,200.00	24,642,910.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,919,200.00	20,919,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	3,723,710.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,382,941,000.00	3,313,886,518.78
2200	Дотоод эх үүсвэрээр	0.0	0.0
220001	Барилга байгууламж	4,060,282,700.00	1,621,688,814.00
221001	Их засвар	714,700,000.00	714,700,000.00
222001	Тоног төхөөрөмж	1,050,458,300.00	455,528,351.78
223001	Бусад хөрөнгө	557,500,000.00	521,969,353.00
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,524,292,100.00	7,344,745,600.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,524,292,100.0	7,344,745,600.00
132001	Орон нутгийн төсвөөс	7,524,292,100.0	7,344,745,600.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	408,723,923.00	283,084,752.52
21	УРСГАЛ ЗАРДАЛ	408,723,923.00	283,084,752.52
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	281,478,109.00	283,084,752.52
210101	Үндсэн цалин	0.00	4,771,063.08
210102	Нэмэгдэл	0.00	21,041,823.87
210201	Тэтгэврийн даатгал	0.00	2,416,698.50
210202	Тэтгэмжийн даатгал	0.00	212,771.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	0.00	418,597.00
210204	Ажилгүйдлийн даатгал	0.00	56,864.80
210205	Эрүүл мэндийн даатгал	0.00	317,481.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1.00	0.00
210304	Байрны түрээс	1.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,615,000.00	0.00
210402	Тээвэр, шатахуун	3,615,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	604,080.00	835,920.00
210604	Урсгал засвар	604,080.00	835,920.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	277,259,028.00	189,592,038.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	277,259,028.00	189,592,038.28
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	127,245,814.00	63,421,494.99
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	127,245,814.00	63,421,494.99
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	335,907,589.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	335,907,589.00	0.00
220001	Барилга байгууламж	335,907,589.00	0.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	392,791,511.00	283,084,752.52
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	392,791,511.00	283,084,752.52
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	383,638,612.00	187,138,903.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,152,899.00	95,945,849.52

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ нь сумын ИТХ, Засаг даргын бодлого боловсруулж, шийдвэр гаргахад нь бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай хүргэн төрийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдийн ажиллах амьдрах таатай орчин бүрдүүлэх, оновчтой бодлого зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон чадварлаг, эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэх чиг үүрэг бүхий Аймгийн Засаг даргын харьяа байгууллага юм.

2023 оныг “Сум орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах, төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэх, төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг чангатган манлайлан ажиллах” зорилго дэвшүүлэн 8 зорилт, 31 ажил, арга хэмжээг төлөвлөн ажилласан. Дэвшүүлсэн зорилго, зорилт, арга хэмжээг 93,9 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн Б/01 тоот тушаалаар байгууллагын бүтэц, орон тоог төрийн захиргааны 9, төрийн үйлчилгээний 7 албан хаагчтайгаар баталж, үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу төрийн байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй үзүүлж сумын үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааг сайжруулж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж ажилласан байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Засаг даргаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь зохион байгуулалт, эрх зүй, аж ахуйн талаар болон Тамгын газрын хэлтэс, албадын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,
- Нутгийн захиргааны байгууллагыг чиглүүлэн удирдахад нь Засаг даргад туслах, Хурал, Засаг дарга, доод шатны нутгийн захиргааны байгууллагыг шаардлагатай мэдээллээр хангах, хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг биелүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд нь хяналт тавьж үр дүнг тооцох
- Тамгын газрын бичиг хэргийг хөтлөх, байгууллага, иргэдээс ирүүлсэн өргөдөл, санал, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, төрийн захиргааны ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйл “Нэгжийн эдийн засгийн үндсийг бүрдүүлэх төр орон нутгийн удирдлага”, 20 дугаар зүйл “Орон нутгийн чиг үүрэг”, 35 дугаар зүйл “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх”, мөн Төсвийн тухай хуулийн зарим зүйл заалт тухайлбал 8 дугаар зүйл “Төсвийн цагалбар”, 23 дугаар зүйл “Төсвийн орлого”, 24 дүгээр зүйл “Төсвийн зарлага”, 27 дугаар зүйл “Төсвийн төсөлд тавигдах шаардлага”-д өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна. Тус байгууллагын дотоод хяналтыг төрийн сангийн мэргэжилтэн нь хариуцан гүйцэтгэдэг бөгөөд хараат байдалтайгаар ажиллаж байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ нь дотоод аудитын нэгжгүй бөгөөд Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, аудитын алба хариуцан гүйцэтгэж байна. 2023 онд тус байгууллагын үйл ажиллагаанд Санхүү хяналт, аудитын албанаас аудит хийгээгүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Санхүү төрийн сангийн хэлтсийн 2012 оны "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг мөрдөн ажиллаж байна. Тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцээгүй бөгөөд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газар нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэж, 2024 оны 1 дүгээр сарын 24-ний 03/01 албан тоотоор Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,619,769.9 мянган төгрөгөөр буюу 71,8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
А	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	12,532.1	616,432.2	603,900.1
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	707,603.7	72,786.1	(634,817.6)
Үндсэн хөрөнгө	1,535,534.6	3,186,222.0	1,650,687.4
Нийт хөрөнгө	2,255,670.4	3,875,440.3	1,619,769.9
Өр төлбөр	-	4,433.2	4,433.2
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,255,670.4	3,871,007.1	1,615,336.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	2,255,670.4	3,875,440.3	1,619,769.9

Авлага данс 603,900.1 мянган төгрөгөөр өссөн сумын ахуйн үйлчилгээний барилгын 615,907.6 мянган төгрөгийн урьдчилгаа төлбөрийг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэснийг аудитын явцад залруулга хийсэнтэй холбоотой байна. Өмнөх оны үлдэгдэл

12,532.1 мянган төгрөгөөс 12,000.0 мянган төгрөгийг хааж, 532.1 мянган төгрөгийн авлага барагдаагүй байна.

Бараа материал дансны хувьд барилгын засварын материал 1,135.9 мянган төгрөг, бусад хангамжийн материал 386.8 мянган төгрөгөөр нэмэгдэж, тусгай зориулалтын материал 6,352.5 мянган төгрөг, бичиг хэргийн материал 1,059.1 мянган төгрөг, аж ахуйн материал 13,021.2 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж, орон сууц 1,593,521.0 мянган төгрөг, тээврийн хэрэгсэл 139,468.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 14,933.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 103,939.0 мянган төгрөг, шилжүүлсэн 11,667.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал 251,551.1 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,871,007.0 мянган төгрөг болж 1,615,337.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 7,086,675.6 мянган төгрөг, нийт зарлагыг 7,086,675.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын тамгын газраас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 200,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 2023 оны урсгал зардлын төсвийг 7,286,675.6 мянган төгрөгөөр баталж, санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 2,822,075.5 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 4,464,600.1 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын ИТХ-ын 2023 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн өдрийн 83 дугаар тогтоолоор тайлант оны батлагдсан төсөв 7,286,675.7 мянган төгрөгийг 227,616.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 7,514,292.1 мянган төгрөгөөр тодотгол хийгдсэн байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага, хүрээлэн буй орчны бодлого, удирдлага гэсэн 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг 2,965,117.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 4,549,174.3 мянган төгрөгийг урьд оны шилжих үлдэгдлээс санхүүжүүлснээс 3,332,263.6 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 4,182,028.5 мянган төгрөг буюу 55.7 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын 3,810.9 мянган төгрөг, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлын 608.9 мянган төгрөг, баг хорооны үйл ажиллагааны зардлын 4,299.7 мянган төгрөг, бусад зардлын 3,069,054.5 мянган төгрөг, байгаль хамгаалах, нөхөн сэргээх зардлын 254,475.5 мянган төгрөгийг зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Үндсэн үйл ажиллагааны зардал	586,903.30	583,092.38	3,810.92	99.4
2	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	90,280.60	89,671.64	608.96	99.3
3	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Баг, хорооны үйл ажиллагааны зардал	126,772.50	122,472.78	4,299.72	96.6
4	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	21,919.20	21,919.20	-	100.0
5	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Бусад	6,382,941.00	3,313,886.52	3,069,054.48	51.9
6	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Орон нутгийн нөөц хөрөнгө	10,000.00	9,986.00	14.00	99.9
7	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	295,475.50	41,000.00	254,475.50	13.9
	Дүн	7,514,292.10	4,182,028.52	4,182,028.52	55.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсөв захирагчаас төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл цалинд зориулан 39,460.1 мянган төгрөг, малын тооллого хийхэд зориулан 618.2 мянган төгрөг, өвс тэжээл борлуулсан орлого 79,233.0 мянган төгрөг, усны болон түрээсийн орлого 5,527.4 мянган төгрөг, урьд оны шилжих үлдэгдлээс 147,060.7 мянган төгрөг, бусад 11,185.5 мянган төгрөг нийт 283,084.8 мянган төгрөгийн орлого орсон байна. Үүнээс төрийн албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл цалин, нийгмийн даатгалын зардалд 29,235.3 мянган төгрөг, урсгал зардалд 835.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 189,592.0 мянган төгрөг, нийт 219,663.3 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 63,421.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансны орлого, зардлын зарцуулалтыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт хоёр хөтөлбөрийн 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70106- Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага	2023.01.01-2023.12.31	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлэх	Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөр 57,4 %	7,218,816.6	4,141,028.5
2	71411- Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	2023.01.01-2023.12.31	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлагыг хэрэгжүүлнэ.	Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөр 13,9%	295,475.5	41,000.0

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар нь Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага /70106/ хөтөлбөр 92,8 хувиар, Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага /71411/ хөтөлбөр 66,8 хувиар хэрэгжсэн нь 2023 оны төсвийн жилд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласантай холбоотойгоор хэмнэгдсэн 55,202.8 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн хур хог хаягдал, орчны бохирдол арга хэмжээ 9 хувьтай хангалтгүй хэрэгжсэн байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу нээлттэй тендерийн зарыг tender.gov.mn цахим хуудсаар зарлаж, ахуй үйлчилгээний барилга барих, ажилчдын автобус, морины хөшөөний тохижилт, сумын өндөрлөг барих зэрэг бүтээн байгуулалтын ажлууд хийгдсэн байна.

Ерөнхий гэрээгээр худалдан авалт хийгдээгүй байна. Энэ нь цахим дэлгүүрт бүртгэгдсэн бараа, ажил үйлчилгээний сонголт бага, өртөг зардал өндөр байгаа тул өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар шийдвэрлэж, шууд худалдан авалт хийж гэрээ байгуулан ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Бямбацогт гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/01 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 2,507,443.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 37,611.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 26,328.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус байгууллага тайлант онд морины шүтээн тохижилтын ажилд 185,464.5 мянган төгрөг, сумын өндөрлөг барихад 94,447.4 мянган төгрөг, Сэргэлэн сум байгууллагдсаны 100 жилийн ойтой холбоотой тэмдэг хийлгэхэд 11,919.6 мянган төгрөг, дууны клип хийлгэхэд 10,000.0 мянган төгрөг, баримтат кино хийлгэхэд 9,700.0 мянган төгрөг, номын эх бэлтгэхэд 19,400.0 мянган төгрөг зарцуулсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.1-д “хөшөө, дурсгал, орон нутгийн угтах, үдэх хаалга барьж байгуулах”, 15 дугаар зүйлийн 15.1.4-д “Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомж, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэр, тэдгээрийн хэрэгжилт, цаг үеийн шинжтэй мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлан таниулахаас бусад зорилгоор байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэсэн заалт болон санхүүгийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 “хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож,

давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасны дагуу албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Сэргэлэн сумын ЗДТГ-ын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 17, зарлагын 2 мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 16 шийдвэрийг хугацаандаа байршуулж, байршуулбал зохих 171 мэдээллээс, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээлэл, хугацаандаа байршуулсан 165 мэдээлэл, хуулийн хэрэгжилт 98,8 хувьтай байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 төлбөрийн акт, 5 албан шаардлага, 1 зөвлөмж өгөгдсөнийг 100 хувь хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 03/32 тоотой ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	3	489.4	3	489.4	100
Албан шаардлага	5	246,061.3	5	246,061.3	100

Зөвлөмж	1	200,845.2	1	200,845.2	100
Нийт дүн	9	447,395.9	9	447,395.9	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар нь дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар сумын хөгжлийн бодлогын төлөвлөгөө, авлага хаасан бичилт, анхан шатны баримт, 100 жилийн ойтой холбоотой зардал, Гадаад иргэн харьяатын газрын ажилчдын автобустай холбоотой асуудлыг авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 436,873.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс, аудитын явцад 436,873.8 мянган төгрөгийн алдааг алдааг НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10 “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” гэсэн заалтыг үндэслэн залрууллаа. Үүнд:

- Тус байгууллага нь 22,740.8 мянган төгрөгийн томилолт, албан тушаалтанд олгосон тэтгэмжийг өглөг дансанд бүртгэлгүй зардал дансанд бүртгэж хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Төрийн банкны дансанд хийгдсэн 6,500.0 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгээгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй байгаа газар эзэмших эрхэд 380.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Цалингаас суутгасан НДШ, ХХОАТ 101,599.0 мянган төгрөгийг бүртгэхдээ цалингийн өглөг дансанд бүртгэлгүй зардал дансанд бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- Сэргэлэн сумын ЗДТГ-т бүртгэлтэй трактор, 50 га газрыг Атрын шим ХХК-тай ногоон тэжээл тарих, хамтран ажиллах гэрээний дагуу авсан 10,000.0 мянган төгрөгийн тэжээлийг үнэ төлбөргүй хүлээн авсан орлогоор, ЗДТГ-ын даргын 2023 оны 02 сарын

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

15-ны өдрийн А/30 дугаар тушаалаар 12,569.2 мянган төгрөгийн бараа материалыг акталсныг бүртгэхдээ бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дансанд бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

- Нэмэлт санхүүжилтийн тайланд 283,084.7 мянган төгрөгийн орлого, зардлыг тайлагнаагүй, тайлан гаргаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 638,556.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 10,858.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, 365,958.1 мянган төгрөгийн албан шаардлага, 261,740.4 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

Төв аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн Б/02 тоот захирамж, Сэргэлэн сумын ЗДТГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн Б/01 тушаалын дагуу сумын төрийн улс төрийн албан хаагчийн орон нутгийн нэмэгдлийг төсөвтөө багтаан шийдвэрлэх гэсэн дагуу 7 албан хаагчдад хавсран ажилласны нэмэгдэлд 10,858.3 мянган төгрөг олгосон байна. Энэ нь Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр “Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” тогтоол, 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар “Журам батлах тухай” тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3 “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” төлбөрийн акт тогтооно гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

5.2 Албан шаардлага

Харилцагч байгууллага, иргэнтэй хийсэн худалдан авалтыг төлбөрийн цахим баримт, нэхэмжлэхийн дүнтэй тулгалт хийхэд 28,061.1 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Сангийн сайдын 347 дугаар тушаалын “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5-д “Төлбөрийн баримт” заалтыг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” үүссэн бол албан шаардлага өгнө гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

Тохижилт үйлчилгээ, их завсрын ажлын урьдчилгаа санхүүжилт 197,398.9 мянган төгрөг, цалингийн урьдчилгаа 28,698.1 мянган төгрөгийг олгохдоо өглөг дансанд бүртгэж зардал руу хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” заалт, “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгнө гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

ТӨАСЭСЗДТГ/202309107 дугаартай гэрээгээр Гадаадын иргэн, харьяатын газар-агаарын замын боомт хариуцсан газрын ажилчдын автобусыг төсвийн хөрөнгө 99,800.0 мянган төгрөгөөр худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-д “төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, 6.6.2-т “төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх”, 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” заалтыг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11 хууль, тогтоомж гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” албан шаардлага өгнө гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

Өмнөх оны авлагын үлдэгдэл 12,000.0 мянган төгрөгийг зардал дансанд бичилт хийж хаасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” заалт болон “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны а/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.1-д “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж баталгаажуулаагүй” бол албан шаардлага өгнө гэсэн заалтыг үндэслэн шийдвэрлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 261,654.0 мянган төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7-д “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” тухай заалтыг болон санхүүгийн тайлангийн “Үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг цаашид ашиглах боломжтой бол дахин үнэлэх, боломжгүй бол эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх.

2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилт

Үндсэн хөрөнгийн барилга байгууламжийн тоог газар эзэмших эрхийн бүртгэлтэй тулгахад зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” заалт, санхүүгийн тайлангийн “үнэлгээ ба хуваарилалт” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Газрын асуудал хариуцсан байгууллагад уламжлан байгууллагын эзэмшиж байгаа газрын эрх, кадастрыг гаргуулж бүртгэх

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд ирүүлж, акт зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн дотор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн банкны 311801848831 дугаарын дансанд хийгдсэн ажил гүйлгээг бүртгээгүй байна.	1	6,500.0	1	6,500.0			1	6,500.00
Олгосон томилолт, албан тушаалтанд олгосон тэтгэмж өглөг дансанд бүртгэлгүй зардал дансанд бүртгэж хаасан байна.	1	22,740.8			1	22,740.8	1	22,740.78
Сэргэлэн сумын ЗДТГ-т бүртгэлтэй трактор, 50 га газрыг Атрын шим ХХК-тай ногоон тэжээл тарих, хамтран ажиллах гэрээний дагуу авсан тэжээлийг үнэ төлбөргүй хүлээн асан орлого гэж бүртгэсэн	1	10,000.0			1	10,000.0	1	10,000.00
ЗДТГ-ын даргын 2023 оны 02 сарын 15-ны өдрийн А/30 дугаар тушаалаар бараа материалыг акталсныг бүртгэхдээ бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал дансанд бүртгэсэн	1	12,569.2			1	12,569.2	1	12,569.21
• Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй байгаа газар эзэмших эрхэд 380.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан	1	380.0			1	380.0	1	380.00
Цалингаас суутгасан НДШ, ХХОАТ-ыг бүртгэхдээ цалингийн өглөг дансанд бүртгэлгүй зардал дансанд бүртгэсэн	1	101,599.0			1	101,599.0	1	101,599.03
Нэмэлт санхүүжилтийн тайланд 283,084.7 мянган төгрөгийн орлого, зардлыг тайлагнаагүй, тайлан гаргаагүй байна.	1	283,084.8	1	283,084.8			1	283,084.75
Дүн	8	436,873.8	2	289,584.8	6	147,289.0	8	436,873.77

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо
Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс зөрүүтэй байна.	1	28,061.1			1	28,061.06				
Тохижилт үйлчилгээ, их завсарын ажлын урьдчилгаа санхүүжилтийг олгохдоо өглөг дансанд бүртгэж зардал руу хаасан байна.	1	197,398.9			1	197,398.94				
ТӨАСЭСЗДТГ/202309107 дугаартай гэрээгээр Гадаадын иргэн, харьяатын газар-агаарын замын боомт хариуцсан газрын ажилчдын автобусыг төсвийн хөрөнгөөр худалдан авсан байна.	1	99,800.0			1	99,800.00				
Цалингийн урьдчилгаа, багийн тохижилтын ажлын урьдчилгаа төлбөрийг өглөг дансанд бүртгэсэн	1	28,698.1			1	28,698.06				
Өмнөх оны авлагын үлдэгдлийг зардал дансанд бичилт хаасан	1	12,000.0			1	12,000.00				
Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 261,740.4 мянган төгрөгийн өртгөтэй 67 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.	1	261,740.4					1	261,740.4		
Биет бус хөрөнгөнд бүртгэлтэй байгаа газар эзэмших эрхийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа барилга, байгуулалмжтай тулгахад дутуу бүртгэсэн байна	1	0.0					1	0.0		
Улс төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгосон байна	1	10,858.3	1	10,858.3						
Дүн	8	638,556.8	1	10,858.3	5	365,958.1	2	261,740.4		

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Морины шүтээн тохижилтын ажилд 185,464.5 мянган төгрөг, сумын өндөрлөг барихад 94,447.4 мянган төгрөг, Сэргэлэн сум байгуулгагдсаны 100 жилийн ойтой холбоотой тэмдэг хийлгэхэд 11,919.6 мянган төгрөг, дууны клип хийлгэхэд 10,000.0 мянган төгрөг, баримтат кино хийлгэхэд 9,700.0 мянган төгрөг, номын эх бэлтгэхэд 19,400.0 мянган төгрөг зарцуулсан байна	1	330,931.5			1	330,931.5		
Дүн	1	330,931.5			1	330,931.5		